

Сэдэв 5: Тогтвортой хөгжил, жендэрийн эрх тэгш байдал

Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчдөө!
Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

НҮБ-ын дэвшүүлсэн тогтвортой хөгжилд хүргэх 17 зорилгын тавдугаарт жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудал орсон байдаг. Үүнийн дотор улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах зорилт тавигдсан. Парламент, орон нутгийн эрх барих хуралд суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь болон удирдах албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувийг өсгөж чадсанаар энэ зорилт биелэлээ олох юм.

Энэ хүрээнд нөхцөл байдлыг илэрхийлж буй статистик тоо баримтыг авч үзвэл:

- 2021 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын бараг 51% нь эмэгтэйчүүд байна.
- Жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр манай улс 71.6 хувиар нийт 156 орноос 69 дүгээр байранд орж байна.
- 2021 оны эхний хагасын байдлаар Монгол Улс парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувиар /17.3%/ байгаа нь нийт 193 орноос 127 дугаар байранд жагсаж байна. Энэ нь олон улсын болон бүсийн дунджаас доогуур үзүүлэлт.
- 2020 оны УИХ-ын сонгуульд нийт 606 хүн нэр дэвшиж өрсөлдсөнөөс тэдгээрийн 151 нь буюу 25% нь эмэгтэй нэр дэвшигч байсан. Сонгуулийн үр дүнд 13 нь л УИХ-ын гишүүнээр сонгогдсон.
- 1992 оноос хойшхи УИХ-ын 8 удаагийн сонгуулийн дүнд нийт 608 гишүүн сонгогдсоноос давхардсан тоогоор 64 нь л эмэгтэй гишүүд байжээ. Эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 1992 онд 5.3% байсан бол 2016, 2020 онуудад 17% болж өссөн байна.
- УИХ-д нэр дэвшигчдийн тоог авч үзвэл орон нутгийн тойргуудад нийслэл Улаанбаатар хотын тойрогтой харьцуулахад харьцангуй цөөн тооны эмэгтэйчүүд нэр дэвшиж байна.
- Сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд давхардсан тоогоор нийтдээ 1814 хүн нэр дэвшсэнээс 430 нь буюу 23.7% нь эмэгтэйчүүд байсан. Орон нутгийн тойрогт нэр дэвшигчдийн 18 хувь нь л эмэгтэйчүүд байгаа бол, нийслэл Улаанбаатар хотын тойргуудад нэр дэвшигчдийн 30% нь эмэгтэйчүүд байна.
- Монгол Улс 2021 оны 6 сарын байдлаар нийт 294 олон талт гэрээнд нэгдэн орсон бөгөөд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий олон улсын гэрээ, хэлцлүүдэд гарын үсэг зурж, нэгдэн орсон байна.

Монгол улс тогтвортой хөгжлийн зорилгын тавдугаар зорилгод хүрэхийн тулд хийж амжуулсан томоохон ажил бол Үндсэн хуулийн өөрчлөлт хийсэн явдал байлаа. Энэ асуудлын хүрээнд ХҮН нам иргэд, сонгогчидтой уулзах, таниулах зорилгоор хоёр жил гаран нийслэл хот, орон нутгаар явж “Хамтдаа өөрчилье” аяныг өрнүүлсэн. Эрх барьж буй нам болон бусад намууд хамтдаа зорьж, зөвшилцсөний эцэст сонгуулийн хувь тэнцүүлсэн холимог тогтолцоо бий болж, гишүүдийн тоо 50-иар өссөн нь шийдвэр гаргах түвшинд орхигддог эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл парламентад орж ирэх боломжийг эрс нэмэгдүүлж байгаа юм.

Түүнчлэн сонгуулийн тухай хууль болон улс төрийн намын тухай хуулийн төслүүд ид хэлэлцэгдэж байгаа энэ цаг үед ярилцаж, хэлэлцэж, дэвшүүлэх ёстой чухал шийдлүүдэд дараахийг дурдаж болно. Үүнд:

- Нийгэм дэх жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх
- Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн төрийн санхүүжилтийн механизмыг бий болгох
- Эмэгтэй нэр дэвшигчдэд сонгуулийн тогтолцооноос үл хамааран төрөөс нэмэлт санхүүжилтийн дэмжлэг шууд үзүүлэх. Өмнөд Солонгост тодорхой хувь хэмжээнээс давсан тооны эмэгтэй нэр дэвшигчтэй бол тухайн хүн тус бүрт сонгуулийн зардлыг нөхөх зорилготой нэмэлт санхүүжилт олгодог байна. Харин Финландад 12, Колумбид парламентад суудалтай намууд нийт төсвийн дэмжлэгийнхээ таван хувийг эмэгтэйчүүдийн бүлгийг дэмжихэд зарцуулах хуультай байдаг байна.
- Сонгуульд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангахад дэмжсэн квот тогтоох. Саяхны чуулганы хэлэлцүүлгээр квот 40% байхаар яригдаж байна. ХҮН намын зорилт бол ХҮН 50/50 бодлогынхоо хүрээнд эмэгтэйчүүд нэр дэвших квотыг 50% хүргэхээр ажиллаж байна.
- Эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн бүртгэлийн хураамжийг багасгах, сонгуулийн сурталчилгаатай холбоотой зардлын зарим зүйл заалтыг хасах, зардлыг эрс бууруулах, хязгаар тавих, телевизийн сурталчилгааны цагийг зохицуулах бусад өөр нэмэлт хувилбар, боломжийг судлан хэрэгжүүлэх
- Сонгууль шударга явах бүхий л бололцоо, боломж, хяналт, хариуцлагын системийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Түүнчлэн Монгол дахь жендэрийн нөхцөл байдлын талаарх бусад тоо баримтыг нэмж дурдвал:

- 2022 онд Монгол улс дэлхийд жендэрийн тэгш байдлын үзүүлэлтээрээ нийт 146 орноос 70-р байрт жагсчээ.
- 2022 оны “Дэлхий нийтийн жендэрийн зөрүүтэй байдлын тайлан”-д дурдсанаар Монгол улс эдийн засгийн оролцоо болон боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтээр дэлхийн дундажтай адил эсвэл түүнээс дээгүүр байгаа боловч, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх тухайд Монгол улс дунджаас доогуур оноо авчээ.
- Монгол улсад их, дээд сургууль төгсөгчдийн 60 хувь нь эмэгтэйчүүд боловч дунд шатны менежерүүдийн зөвхөн 30 хувь нь, дээд түвшний менежерүүдийн зөвхөн 15 хувь нь эмэгтэйчүүд байна.

Монгол улс хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлын тухайд ерөнхийдээ сайн үзүүлэлттэй байгаа хэдий ч хөдөлмөр эрхлэлт, боловсролын хувьд жендэрээр хуваагдах, ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, дундаж насжилт болон чанартай эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, их, дээд сургууль төгсөгчдийн тоо гэх мэт шийдвэрлэвэл зохих томоохон зарим саад бэрхшээл оршсоор байна.

Тиймээс цаашдаа зөвхөн улс төрийн оролцооноос гадна бүх түвшинд жендерийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, хүчирхэгжүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль тогтоомжийг батлан сайжруулах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд төсөв хуваарилдаг, хянах тогтолцоотой болох шаардлага тулгарч байгаа юм.

Эмэгтэйчүүдийн оролцоо шийдвэр гаргах түвшинд хангалттай бий болсноор Монгол улс нийгэм, эдийн засгийн хөгжлийн гацаанаас гарах, авлигаас ангид байх, аливаа

шийдвэрүүд ил тод болох, хууль дүрэм журмын хэрэгжилт сайжрах гэх мэт олон талын өндөр ач холбогдолтой юм.

Анхаарал хандуулсан баярлалаа